



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1199

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дизель генераторын худалдан авах ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын
нярав)
М.Бат-Өлзий (Засаг даргын Тамгын газрын жолооч)

2. Захиалагчийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний үүргийг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д, хөрөнгийг байгууллагын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

3. Дизель генераторын ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг өмч хамгаалах байнзгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА САМГАЛАН

